



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/295.

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн гуравдугаар хуралдааны 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 онд хэрэгжүүлэх Төсөл, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.21 дэх заалт Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрт батлагдсан төсвөөс Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас нийлүүлэгдсэн газар тариалангийн чиглэлийн техник, тоног төхөөрөмж тээвэрлэсэн 6.700.00 төгрөг /зургаан сая долоон зуун мянган/-ийн зардал олгохыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.


2. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/295-Bo
02 1335

Аймгийн Засаг даргын 2021 оны
06 дугаар сарын 16-ны өдрийн
А/295 дугаар захирамжийн хавсралт



“ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ САН”-ГААС ОЛГОГДСОН ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙГ ТЭЭВЭРЛЭХЭД ГАРГАСАН ЗАРДАЛ

№	Тээврийн зардал	Төсөвт өртөг
1	Улаанбаатар хотоос /Ховд аймаг Жаргалант сум/ тээвэрлэлтэнд зарцуулсан зардал	6.000.000
2	Ачаа ачих краны зардал	500.000
3	Ачаа буулгах краны зардал	200.000
Нийт		6.700.000

-oOo-